



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 02/17

Баян-Өндөр сум

Орон нутгийн өмчит компаниудын
хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хавсралтаар томилсугай.

2.Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан эрхийг олгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлд, хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг холбогдох хууль, дүрэм, журамд заасан мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Ц.Эрдэнэчимэг)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010010

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025
оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Ээлжит II
хуралдааны 02/17 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Цахим бодлогын хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүйн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн хорооны дарга
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дэд бүтэц, хот байгуулалт, гэр хорооллын хөгжлийн хорооны дарга